

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА

2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр, Баасан гараг

	Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
	Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 5
	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6 - 34
1.	Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа	6 - 12
2.	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээлэл /хаалттай/	
3.	“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	17 - 31
4.	“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	31 - 34

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
03 дугаар сарын 15-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 06 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Х.Баделхан, Э.Бат-Амгалан, Д.Батлут, Б.Баттөмөр, Б.Баярсайхан, Х.Булгантуяа, Ц.Даваасүрэн, Ц.Мөнх-Оргил, С.Одонтуяа, Ч.Хүрэлбаатар, Д.Цогтбаатар, Б.Чойжилсүрэн, Л.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Н.Ганибал, Т.Доржханд;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Х.Болорчулуун, Ш.Раднаасэд;

Тасалсан: Ж.Батсуурь, Б.Жавхлан.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн  
ажиллагаа**

“Их эзэн Чингис хаан” танхим дахь Төрийн далбааны дэргэд хүндэт харуул зогсож, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ нар суудлаа эзэлсэн байлаа.

Танхимын голд байрлуулсан дэлгэц дээр **“МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ НЭЭЛТ 2024.03.15”** гэсэн бичиг гарч байв.

“Их эзэн Чингис хаан” танхимд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, Дотоод аудитын албаны дарга бөгөөд дотоод аудитор Я.Баттогтох, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд, Цахим парламент, инновацын газрын дарга С.Тамир, Парламентын судалгааны хүрээлэнгийн захирал Ц.Цогзолмаа, Улсын Их Хурлын даргын Ажлын албаны дарга Б.Энх-Ундрэм, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны дарга С.Далхаасүрэн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн Ажлын албаны дарга Б.Энхмөнх нар;

Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Соёлын сайд Ч.Номин, Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга А.Бямбажаргал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Монгол Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан, Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загжав, Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн,

Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр нар биечлэн, Монгол Улсад суугаа гадаад орнуудын Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн болон Олон улсын байгууллагын Монгол Улс дахь суурин төлөөлөгчид цахимаар оролцов.

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганыг нээж үг хэлэв.

Үг хэлж дууссаны дараа танхимд Төрийн дуулал эгшиглэхэд Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүд болон нээлтийн ажиллагаанд оролцогчид босож хүндэтгэл үзүүлэв.

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэв.

*Нээлтийн ажиллагаа 10 цаг 24 минутад өндөрлөв.*

#### ***Хоёр. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээлэл /хаалттай/***

*Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан 10 цаг 25 минутаас хаалттай горимоор Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээллийг хэлэлцэж, 11 цаг 48 минутад нээлттэй горимд шилжин хуралдаан үргэлжлэв.*

#### ***Гурав. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Д.Ганбат, С.Бямбацогт, Б.Бат-Эрдэнэ, Ц.Мөнхцэцэг нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг бүхэлд нь батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 19  
Бүгд: 41  
53.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 12 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.*

**Дөрөв. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг бүхэлд нь батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22  
Татгалзсан: 19  
Бүгд: 41  
53.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:53/

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:55/

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалангаас Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулдаг Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх олон улсын “PISA-2022” үнэлгээний Монгол Улсын үр дүнгийн талаарх Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийн товгыг хойшлуулж өгөхийг хүссэн албан бичгийг танилцуулав.

Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нээлтийн ажиллагааг Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын студи болон бусад хэвлэл мэдээллийн байгууллагын зураглаач, гэрэл зурагчид сурвалжлав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 1 цаг 26 минут үргэлжилж, 72 гишүүнээс 50 гишүүн хүрэлцэн ирж, 69.4 хувийн ирцтэйгээр 12 цаг 56 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
10 цаг 06 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн

### Нэг.Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа

Ингээд Улсын Их Хурлын хаврын чуулганыг нээж үг хэлье.

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд аа,

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Хүндэт зочид оо,

Та бүхэндээ энэ өдрийн мэндчилгээг өргөн дэвшүүлье.

Монгол Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулган эхэлж байна. /алх цохив/

Энэ чуулган 2020 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан парламентын бүрэн эрхийн хугацааны “отгон” чуулган болж байна.

хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Засгийн газрын гишүүд, Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Ерөнхийлөгчийн Тамгын Газрын дарга зэрэг төрийн өндөр албан тушаалтнууд, Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагуудын болон нийслэлийн удирдлагууд биечлэн, Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар болон олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газруудын тэргүүн нар цахимаар уригдан оролцож байна.

Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулган эхлэхэд бэлэн болсон. Ирц 55 хувьтай болсон байна.

Тэр ч утгаараа төр, ард түмнийхээ итгэлийг хүлээж сонгогдсон Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бүхний энэ парламентын хувьд онцгой чухал ач холбогдолтой чуулган байх ёстой.

Өнгөрсөн 4 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн цогц өөрчлөлт шинэчлэлтээ гүнзгийрүүлж, хэрэгжүүлж дуусгах нь энэ чуулганы зорилт байх болно.

**Өнөөдөр тогтолцооны цогц реформын томоохон үр дүнг баталсан онцлог чуулган болж байгааг Та бүхэн энэ танхимаас харж байна.**

Ард түмний төлөөллийг нэмэгдүүлэх, өргөтгөл шинэтгэлийн ажлын нөхцөл байдлын улмаас ардчилсан парламент бүрэн бүрэлдэхүүнээрээ

“Чингис хаан” танхимдаа хуралдаж байна.

Өнөөдөр түүхийн тохиолоор 30 гаруй жилийн дараа алдаанаасаа суралцсан, гажуудлаа зассан, тогтолцоогоо чамбайруулсан, хөгжлөө түргэтгэн, үндэстнээ хүчирхэгжүүлэн урагшлуулах “Шинэ 30 жил”-ийг эхлүүлэх түүхэн цаг үеийн гэрч оролцогч нар болон та бид энд сууж байна.

Энэ удаагийн парламент ачааны хүндийг тулж, улс төрийн ширүүнийг туулж, их шинэчлэлийн цөмийг үүрч, элдэв гажуудлын мууг нь халшралгүй шингээн давж, парламентын засаглалын суурийг ганхуулалгүй нийгмийн суурь шинэчлэлийн бат бэх суурийг тавьж чадсан гэдгийг онцлон хэлэх нь зүйтэй.

*Олон жил гацсан нийгмийн суурь гажуудлын үүсгэгч тогтолцоо, засаглалын хямралт байдлыг бид зөвлөлдөн зөвшилдөх замаар засаж залруулж чадлаа.*

“Чадлаа” гэх энгийн үгэн дотор Монгол Улсын олон суурь асуудлууд гацаанаас гарсныг хожим түүх үнэлнэ гэдэгт огтхон ч эргэлзэхгүй байна.

Монгол Улсынхаа язгуур эрх ашгийн төлөө улс төрийн эр зориг гаргасанд намчирхал, талцлаас илүү язгуур эрх ашигтаа үнэнч үйлчилж, улсынхаа үсрэнгүй хөгжил, хүчирхэгжилтийн гүн бат суурийг тавих үйлсэд гар бие, сэтгэл зүрхээ зориулсан Та бүхэнд гүн талархал илэрхийлж байна.

Монгол Улс цэгцрэн тэгшрэх, сэргэн мандах эргэлтийн цаг үеийн босгон дээр 8 дахь удаагийн парламент үйл ажиллагаагаа явуулж байна.

Бид “Шинэчлэлийн парламент” байхыг зорилгоо болгож, сэргч сэхээрсэн ард олны “Цэгцрэх хөдөлгөөн”, “Шинэ сэргэлт”-ийн бодлогоо дэвшүүлсэн Засгийн газартайгаа нэг зүгт харж, нэгдмэл эрмэлзэлтэй байж чадаж байгаа нь энэ парламентын илэрхийлэх нэг онцлог юм.

Монгол Улс бол хуулийн засаглал, хувь хүний эрх чөлөөт эдийн засгийн тогтолцоог эрхэмлэгч, сонгуулиар төр, засгаа эмхлэн бүрдүүлдэг “ардчилсан улс”.

Энэ шинэ замыг сонгосон 30 гаруй жилд бид ардчилсан тогтолцоогоо улам баталгаажуулах, улсаа хөгжүүлэх, эрх чөлөөт, шударга нийгмийг төлөвшүүлэх, ард нийтээрээ сайхан амьдрахын төлөө л зорьсон.

Гэхдээ бодож төсөөлснөөс асуудал зарим чиглэлээр өөрөөр эргэж, үр дүн хүссэн хэмжээнд хүрсэнгүй өнөөдөрт хүрсэн.

Тиймээс өнгөрсөн туршлага, сургамжаа шүүн тунгаах, алдаа бурууг засаж залруулах, үүний тулд тогтолцооны шинэчлэл хийхэд чиглэсэн эрмэлзлэл сүүлийн 4-өөс 5 жилд эрчилсэн давлагаа болж өрнөж байна.

*Энэ эмх замбараагүй мэт санагдаж болох ч энэ бол цэгцрэх хөдөлгөөн гарцаагүй мөн юм.*

Чиглэлийг нь тодорхойлж үл болох үй түмэн молекулуудын эмх замбараагүй хөдөлгөөнийг нэг зүгт эмхлэн чиглүүлбэл энерги болж хувирдаг гэсэн физикийн ердийн онол нийгмийн хөгжил хөдөлгөөнд ч гэсэн хамаатай.

Цэгцрэхийн төлөөх ард олны энэ эрчилсэн хөдөлгөөнийг Улсын Их Хурал



мэдэрч шинэчлэлийг түүчээлэгч “шүгэл үлээгч” байж чадсан гэж үзэж байна.

Улс төр судлаач эрдэмтэн Жеймс Вильсон /James Q.Wilson/, Жорж Келлинг /George L.Kelling/ нарын дэвшүүлсэн **“Хагархай цонх”** [Broken windows theory]-НЫ онолыг хамгийн энгийнээр тайлбарлах юм бол **“Цонх хагарвал тэр доор нь шиллэж байх ёстой. Хэрэв ингэхгүй бол дараа дараагийн цонх хагарсаар бүтэн цонх нэг ч үгүй болно.”** гэсэн утгатай.

Энэ бол нийгэмд бий болсон тулгамдсан асуудал, буруу хазгайг тэр доор нь засаж, шинэчилж байхгүй бол тогтолцооны гажуудал болж урхагшина гэсэн үг юм. Өнгөрсөн 30 жилийн дүр зургийг үүнтэй зүйрлэж болно.

Өнгөрсөн 30 жилд манай цонх хагарсаар байсан ч бүтэн болгоход төдийлөн анхаарсангүй. Оролдлогууд мэдээж байсан ч тэр бүр бүтэлтэй болсонгүй.

Албан тасалгааны цонхоор амьдрал сайхан харагддагтай адил хагархай цонхоор жавар салхи, тоос буртаг орж ирсээр улам зузааран хуримтлагдсаар өнөөг хүргэжээ.

Тиймээс Улсын Их Хурал, Засгийн газар энэ хуримтлагдсан гажуудлыг засах эрх зүйн шинэчлэл хийхийг эрхэм зорилгоо болгож ажиллаж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг амилуулах хүрээнд хийсэн **“улс төр, засаглал, эдийн засаг, нийгмийг тогтолцооны эрх зүйн реформ”**-ууд хагархай цонхнуудаа бүтэн болгоод зогсохгүй цаашид цонх хагарахгүй байх дархлааг бий болгоход чиглэсэн юм.

Монгол хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангах нь ардчилсан Монгол Улс оршин тогтохын нэг үндсэн баталгаа юм.

Энэ бүх шинэчлэлүүд маш олон чиглэлээр олон шинэчлэлүүд хийгдсэн. Чуулган болгон өөрийн онцлогтой болж ирлээ. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд.

**2021 оны хаврын чуулган**  
**“Хүний эрхийг дээдлэх”** чуулган болгон зарлаж, Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг Ази тивдээ анх удаа баталсан.

Монгол хүний эрх чөлөө аюулгүй байдлыг хангах, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх шинэ тогтолцоог бүрдүүлсэн.

Иргэдийн зөрчигдсэн эрхийг сэргээх, хилс хэргээр яллахгүй байх, эрүүдэн шүүлтийг зогсох чиглэлд бодитой ахиц өөрчлөлт гарч эхэлсэн.

**2023 оны хаврын чуулган**  
**“Авлигалын эсрэг”** чуулган болгон зарлаж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, Нийтийн албанд хувийн эрх, ашиг сонирхлыг зохицуулах тухай хууль, Эрүүгийн хуульд авлигын ялын бодлогыг чангатгах зэрэг хуулиудыг баталж, авлигаас ангид нийгэм, авлигаас татгалздаг ёс зүйтэй төрийн албатай болох, ард түмний нэр барьсан популизм, ёс зүйгүй байдлыг таслан зогсоох нь Монголын төрийг, Монголын нийгмийг авлигалаас ангижруулах үндсэн хүчин зүйл мөн.

*Улс төр, засаглалын реформын хүрээнд Улсын Их Хурлын гишүүдийн тоог 126 болгон нэмэгдүүлж, сонгуулийн холимог тогтолцоотой*

### *болох өөрчлөлтийг 2023 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан.*

Үүнтэй уялдуулан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан, Улс төрийн намын тухай хуулийг баталсан.

Гишүүдийн тоог олшруулсан төдий өөрчлөлт биш. Парламентат ёсоо улам бэхжүүлэх, үндэсний аюулгүй байдлаа хангах, ард түмний хүсэл эрмэлзлэл, засаглах эрх, нийгмийн бүлэг, кластерын төлөөлөл парламентад илүү сайн хангагдаж байх төлөөллийн ардчиллыг төгөлдөржүүлэх, мөнгөний сонгуулиас татгалзахад энэ өөрчлөлт чиглэсэн.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, намууд бодлогын институт болж төлөвших, санхүүжилт нь ил тод байх зарчмыг шинээр тусгасан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, албан тушаал, эрх мэдлээ ашиглан бусдаас давуу байдал эдлэх боломжийг бүрмөсөн хязгаарласан.

Хараат бус бие даасан, шударга шүүхтэй болох Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаанд нийцүүлж Монгол Улсын шүүхийн тухай багц хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан.

Бага Үндсэн хууль гэж нэрлэгддэг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, түүнтэй уялдуулан Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиудыг баталж нутгийн

удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох засаг захиргааны шинэчлэлийн эхлэлийг тавилаа.

Мөн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг баталж хуулийн хэрэгжилтийг хангах хяналт шалгалтын бүрэн эрхээ парламент өөрийн гартаа хэрэгжүүлдэг болсон.

Үүний үр дүнд хяналт босоогоос хэвтээ тэнхлэгт шилжиж ард олон хэвлэл мэдээлэл, иргэний нийгэмтэй хамтарсан хүчтэй шударга хяналтын тогтолцоо бүрдэж байна.

“Хөгжлийн банк”-ны, “Нүүрс”-ний гэх мэт олны анхаарлыг татсан хэргүүдээр парламентад хянан шалгах түр хороо байгуулж, нээлттэй сонгол зохион байгуулснаар улс орон, ард түмний хөгжин дэвжих боломжийг хулгайлсан томоохон луйврын үйлдлүүдийг ил тод болгож, ард түмний мэдэх эрхийг хангасан.

Хөгжлийн бодлого тогтвортой байна гэсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааны дагуу “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2023, 2024 оны улсын хөгжлийн төлөвлөгөө зэрэг урт, дунд, богино хугацааны хөгжлийн төлөвлөгөөнүүдийг баталж, эдийн засагт төсвийн реформыг эхлүүлээ.

Нийгмийн бодлогын хүрээнд нийгмийн даатгалын багц хууль, боловсролын салбарын багц хууль, эрүүл мэндийн хуулиудыг баталж олон жил ярьсан реформыг хэрэгжүүлэхэд чухал алхам хийсэн.

Бүхэлдээ энэ бол хүний хөгжлийн цогц реформыг хэрэгжүүлсэн гэж хэлж

болно. Цалин төсвийг ч гэсэн нэмэгдүүллээ.

Цахим шилжилт хийж **“Гурван D”** буюу **“Цахим парламент”** болгох чиглэлээр бидний хэрэгжүүлсэн олон ажил олон шинэ өөрчлөлтүүдийг авчирч байна.

**“D-Parliament”** систем нь ард түмний засаглах эрхийг хэрэгжүүлэх шинэ боломжийг нээж өгч байна.

Эрхэм гишүүд ээ,

Энэ хаврын чуулганаар эхэлсэн эдгээр

- *эрх зүйн;*
- *эдийн засгийн;*
- *хүний хөгжлийн буюу нийгмийн бодлогын реформуудаа*

эцэслэн дуусгах нь Та бидний эрхэм чухал зорилт байх болно.

Орлогын тэгш бус байдлыг арилгах, тогтвортой өсөлттэй, өсөлтийн үр шимийг нь иргэндээ, айл өрхдөө хүргэдэг, хүртдэг засгийн тогтолцоо бүрдүүлэхийг ард иргэд шаардаж, парламент ч энэ чиглэлд онцгой анхаарч байгаа.

Монгол Улс бол тусгаар тогтносон бүрэн эрхт улс. Үүгээрээ бид бахархдаг.

Харвардын их сургуулийн профессор Ричард Вийторын /Richard H.K.Vietor/ **“Улс орнууд хэрхэн өрсөлддөг вэ”** [How Countries Compete] гэдэг номондоо

*“Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, түүний хүчин чадал нь*

- *хүний нөөц,*
- *технологийн нөөц,*
- *капиталын нөөц,*
- *газар нутаг, байгалийн нөөцөөс хамаарах юм.”* гэжээ.

Тэгвэл бидэнд 1.5 сая ам дөрвөлжин километр өргөн уудам үржил шимт үзэсгэлэнт сайхан газар нутаг бий.

Байгалийн асар их баялгаар дэлхийд гайхагддаг. Өөрөөр хэлбэл Монгол Улс хэнээс ч үл хамааран үнэ цэнтэй оршин тогтнох Монголын ондоошил, ижилслийг дэлхийд дархлах хангалттай боломж байна.

Энэ боломж нь Монгол Улс хөгжлийн эрэмбээрээ дэлхийтэй хөл нийлүүлэх чухал хүчин зүйл мөн.

Түүнийг эрх зүйн шинэчлэлээр дэмжих ёстой.

Үүний тулд Үндэсний баялгийн сангийн тухай хуулиа нэн тэргүүнд батлан гаргах шаардлагатай байна.

Энэ чиглэлээр парламентад суудалтай улс төрийн намын дарга нар тохиролцоонд хүрсэн. Энэ бол энэ хаврын чуулганы тэргүүн ээлжийн нэг зорилт байх ёстой.

*Монгол хүн монгол газартаа, Монголын баялагтаа эзэн нь байх ёстой* гэсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн зарчмыг энэ парламент тууштай мөрдсөн.

Үндсэн хуулийн 6.2-т Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг тодорхой тусгасан.

Үндэсний баялгийн сангийн хууль бол **“Баялагтаа эзэн Монгол”**

хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн суурь нөхцөл юм.

**“D-petition”** системээр иргэдээс ирүүлсэн татвар, нийгмийн даатгал, тэтгэмж, газар эзэмших, ашиглахтай холбоотой нийтийн өргөдлүүдэд бид хуулийн дагуу хариу өгөх ёстой.

Татварын цогц реформ хийх, газрын реформын хуулийг шинэчлэн батлахдаа иргэдийнхээ ирүүлсэн эдгээр саналыг зайлшгүй харгалзан авч үзэх ёстой гэж үзэж байна.

**“Ногоон автобус”**-ны хэрэг, Ашигт малтмалын лиценз, газар олголтын байдалд хяналт шалгалт хийх түр хороог ойрын хугацаанд нээлттэй сонголт зохион байгуулж Монголын баялаг ард түмний өмчийн хулгай луйврыг бас илчлэх ёстой.

Хууль бусаар ашиглаж бусдын гарт ороод байсан Салхитын мөнгөний жижигхэн ордыг төр, ард түмний өмчлөлд буцаан авснаар 240 гаруй мянган иргэдийн тэтгэврийг тэглэж, бас 240 гаруй мянган тэтгэврийн зээл аваагүй ахмадууд 1 сая төгрөгийн тэтгэмж олгож байсан ийм туршлага бол **“Баялагтаа эзэн Монгол”** хөтөлбөрийг хэрэгжүүлэх утвар нөхцөл байсан гэдгийг Та бүхэн санаж байгаа байх.

Ашигт малтмалын том, жижиг ордууд, тэдгээрийн ашиглалт, лиценз, татвар төлөлтийг тойрсон элдэв хэлбэрийн булхай, луйврыг илчлэх нь шударга ёсны зарчимд нийцнэ гэж үзэж байна.

Үүнтэй холбоотойгоор ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн татварын тооллогыг ч гэсэн явуулах ёстой гэж үзэж байгаа.

Шударга бус, ёс зүйгүй байдал, хууль завших үзэгдэл, гэмт үйлдлүүдэд олон нийтийн хяналтыг тогтооход чухал ач холбогдолтой Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг энэ чуулганаар батлахад ажлын хэсэг удаашралгүй шуурхайлах шаардлагатай байна.

Хэдхэн сарын дараа Улсын Их Хурлын ээлжит сонгууль болно. Бүсчилсэн том тойргуудад өрсөлдөөн өрнөнө. Улс төрийн өрсөлдөөн өрнөнө. Нутгийн биш улс төрийн өрсөлдөөн өрнөх учиртай.

Энэ бол 13 тойргоос 126 гишүүн сонгох тоо, хэмжүүрийн асуудал биш, ирээдүйгээ томоор харж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг амилуулах, улс орноо цогцоор нь хөгжүүлэх томоохон реформын эхлэл юм.

Хот, хөдөөгийн ялгааг багасгах, эдийн засгийн нөөцийг зохистой хуваарилах, хөгжлийг урт хугацааны төлөвлөлт, бодлогоор удирдах, үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнол, аюулгүй байдлыг баталгаажуулахад энэ чиглэл, энэ шинэчлэл чухал ач холбогдолтой.

Тиймээс сонгуулийн бэлтгэлийг сайтар хангах, холбогдох дүрэм журмуудыг батлан гаргах нь энэ чуулганы бас нэг чухал зорилт байх болно.

Нөгөө талаар парламентын төлөөллийн чадавхыг сайжруулах, сонгодог парламентыг төлөвшүүлэх, шинжлэх ухаанч мэтгэлцээн, судалгаа шинжилгээнд суурилсан хууль тогтоох засаглалыг төлөвшүүлэх үзэл баримтлалд тулгуурласан Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиудыг батлах чухал үүрэг

хариуцлага биднийг энэ хаврын чуулганаар хүлээж байна.

Эрхэм гишүүд ээ,

Монголын хөдөө цас зудын нэн хүндрэлтэй цаг үед байна. Хүндрэл арилж, мал шинэ ногоотой золгох хүртэл бас нэлээд хугацаа байна.

Тиймээс малчдадаа туслах арга хэмжээг цаашид ч үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байгааг хаана хаанаа бид анхаарах ёстой.

Энэ удаагийн цас зуд Монголын хөдөө аж ахуй, түүний дотроо саланги бутархай, амь аргацаасан мал аж ахуйн салбарт тогтолцооны шинэчлэлт зайлшгүй чухал байгааг батлан харууллаа. Ган, зудад нэрвэгдсэн үед нь өвс, тэжээл зөөж хүргэх, малчдыг урамшуулал, дэмжлэгт хамруулах төдийгөөр асуудлыг шийдэж чадахгүй нь хэнд ч тодорхой.

Ойрын хугацааны шийдлээс гадна бид урт хугацааны шийдлийг эрэлхийлж шийд гаргах цаг болжээ.

Тиймээс Малчин өрхүүдийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг энэ хаврын чуулганаар хэлэлцэн батлах хэрэгтэй байна.

Мал аж ахуйдаа шинэчлэлт, өөрчлөлт хийх, малчдынхаа асуудлыг цогцоор нь шийдэх, бэлчээр, ус, залуу малчдын залгамж халаа гэх мэт энэ цогц олон асуудал хуримтлагдаад тулгараад байгааг шийдэх гарц, гаргалгааг энэ нэгд, ардчилсан санаачилга дээр тулгуурласан хамтын санаачилга хоршиж, хамтарч,

холбоогоор нэгдэж ажиллах шийдэл гэж үзэж байна.

Монгол малчин, монгол мал хоёр бол Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн бүтэн оршихуйн тулгуур багана, хүнсний аюулгүй байдал, иргэдийн эрүүл саруул аж төрөхийн нэг чухал баталгаа төдийгүй нүүдлийн соёл, иргэншлийн өвийг тээж байгаа ийм Монгол уламжлал юм. Үүнийг бид санаж ажиллах учиртай.

Эрхэм гишүүд ээ,

Монголоо гэсэн нэгэн үзүүрт сэтгэлээр **“НЭГ МОНГОЛ”** болж нэгдэх, нэг зүгт хамтдаа харах, **“Цэгцрэх хөдөлгөөн”**-ийг дэмжин түрж, шинэ сэргэлтийг хамтдаа бүтээхийг Монгол Улсын эрхэм гишүүд, нийт ард түмэндээ уриалъя.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулган нээснийг мэдэгдье. /алх цохив/

*(Хаврын ээлжит чуулган нээснийг мэдэгдэн алх цохимогц Төрийн дуулал танхимд эгшиглэв.)*

Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Одоо нэгдсэн хуралдаанаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хаалттай мэдээллийг сонсоно.

Нэгдсэн хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлбье.

Хуралдаан нээлттэй горимд шилжсэн байна. Хэлэлцэх асуудалдаа орно.

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Энэ хугацаатай өнөөдрийн дотор хэлэлцэх ёстой тийм тогтоол юм билээ.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлсэн гишүүд үг хэлнэ гэсэн хуралдааны дэгтэй.

Тэгэхдээ үндэслэл бүхий санал гэдэг маань хэлэлцэх асуудал тодроогүй байхад л хүмүүс үг хэлэх болчихоод байгаа юм.

Ингээд үг хэлэхээр Төмөртоогогийн Энхтүвшин Улсын Их Хурлын даргад 14 цаг 22 минутад “Хүсэлт гаргах тухай” албан бичиг ирүүлсэн.

Уг албан бичигтээ 2024 оны хаврын нэгдсэн хуралдаанаар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэлэлцүүлэх, Хэрлэн-Тооно, Орхон аймгийн төслийн хэрэгжилт, цас зудын нөхцөл байдлын талаар үг хэлэх зөвшөөрөл хүссэн байна.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулж үг хэлэх зөвшөөрөл хүссэн. Нэг асуудалтай.

Тэгэхдээ энэ дээр үндэслэлээ бас тодорхой бичсэн байна.

Энэ хоёр гишүүн үндэслэл бүхий санал ирүүлсэн.

Улсын Их Хурлын гишүүн А.Адьяасүрэн хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулж үг хэлэх зөвшөөрөл олгоно уу гэж хүссэн байна.

Тэгээд хэлэлцэх асуудал, дараалал чинь ганцхан л асуудалтай юм чинь энэ хоёр чинь дээр доор орно гэсэн дараалал байхгүй тул ингээд хасаж байна.

Ингээд Төмөртоогогийн Энхтүвшин гишүүн үг хэлнэ. Т.Энхтүвшин гишүүн алга байна. /алх цохив/

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Монголынхоо ард түмэнд энэ өдрийн мэндчилгээ дэвшүүлье. Сайхан хаваржиж байна уу?

Их Хурлын даргаасаа өгсүүлээд Их Хурлын гишүүд зудтай байгаа орон нутагт чуулганы завсарлагааны үеэр ажиллалаа.

Иргэдийн асуудалтай танилцаж бас тод тодорхой зарим асуудлыг шийдвэрлэсэн.

Тэгэхээр би нийтдээ 41 сумаар явж ажиллалаа. Тойргийнхоо.

Энд ард иргэдийн хэлсэн үгийг төрд хүргэх үндсэн үүрэгтэй. Тэр үүргийнхээ дагуу үг хэлье.

Тэгээд сүүлд нь хэлэлцэх асуудлын дарааллаар үг хэлнэ.

Завхан аймгийн Шилүүстэй сумын Амгайбазар, Цагаанчулуут сумын Эрдэнетуяа, Цагаанхайрхан сумын Энхболд, Нөмрөг сумын Бат-Эрдэнэ, Тэлмэн сумын Батчулуун, Идэр сумын Нарантуяа, Дөрвөлжин сумын Ренчин, Говь-Алтай аймгийн Дарви сумын Д.Дөш, Баян-Уул сумын Оюу, Бугат сумын Д.Дашбал, Алтай сумын С.Зэсэндүйчир, Шарга сумын Идэрмөнх, Увс аймгийн Тариалан сумын Рагчаадорж, Ховд аймгийн Чандмань сумын Цэрэндаваа нар төрд гарч буй авлига, хулгай илэрч байгаа боловч бие биедээ барьцаалагдсан эрх баригч нар нөгөөдөө ерөөсөө хариуцлага тооцохгүй байна.

Одоо энэ парламентаараа л дуусаарай.

Тэгээд шинэ парламентаар энэ нөхдүүддээ хариуцлага тооцоорой гэж байна.

Увс аймгийн Тариалан сумын Цолмон, Говь-Алтай аймгийн Тайшир сумын Болдбаатар, Ховд аймгийн Чандмань сумын Даваасүрэн, Завхан аймгийн Завханмандал сумын Балжинням нар малын түүхий эд, махны үнэ өсгөх, аймаг бүрт үйлдвэр бариач ээ, малчдын зээлийг тэглэж өгөөч ээ гэж хүсэлт тавьж байна.

Завхан аймгийн Отгон сумын Ч.Баасанжав 48 хүн жагсаалтын ард нуугдаж орж ирнэ.

Төрөө самрах вий гэсэн айдас байна. Энэ дээр анхаарлаа тавиарай гэж байна.

Завхан аймгийн Түдэвтэй сумын Цорго багийн Бадамдорж гуай зуд болдгоороо болдог. Ард түмэн малчид давдгаараа давна. Гагцхүү дээр байгаа дарга зудаас салгаж өгөөч ээ, Б.Пүрэвдоржоо гэж байна.

Завхан аймгийн Их-Уул сумын Хонгор багийн С.Цэрэнноров 3 пресс, 2 шуудай тэжээл машиндаа ачаад явахаар 30 мянга, 50 мянгаар торгоод байна. Болиулаач ээ гэж байна.

Хөөе Б.Энхбаяр аа, үүнийг анхаараарай. Сайд аа.

Завхан аймгийн Ургамал сумын Нуурзөөхий багийн Төмөрхуяг 2022-2023 оны ноосныхоо урамшууллын мөнгөө өгчих өө.

Ганц хоёр шуудай тэжээлээр чинь одоо энэ зудны үеэр бид нар яах юм бэ гэж байна.

Завхан аймгийн Алдархаан сумын Өгөөмөр багийн Энхбат Ардчилсан намыг малыг малчдад өгсөн шигээ малчдыг мөнгөжүүлж өгөөч ээ гэж хүсэж байна.

Говь-Алтай аймгийн Жаргалант сумын Авирмэд дарга Сум хөгжүүлэх санг Хоршоог дэмжих сан болгож өөрчилсөн. Нөгөө нэг таны хэрэгжүүлсэн Сум хөгжүүлэх санг хоршоо болгоод хаячхаж.

Тэгээд суманд байдаг ганц хоёрхон хоршоо тэрнээс нь зээл авч

байна. Иргэд нь зээл авах боломжгүй болчихсон.

Тэгээд энэ Монгол Ардын нам чинь угаасаа тэгээд яавал иргэдээ ядуу байлгах вэ л гэж боддог нам шүү дээ.

Тийм учраас энэ талаар би бас энэ бүх асуудлаар бүгд дээр нь тодорхой албан тушаалтнуудад нь захидал, албан бичиг бичнэ.

Тэр дагуу хариу авч энэ ард иргэдэд хариуг нь авч өгнө. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Одоо Төмөртоогогийн Энхтүвшин гишүүн.

**Т.Энхтүвшин:** Баярлалаа. Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэж байна.

Энэ хаврын чуулганаар Дорноговь аймаг, Өмнөговь аймгийн иргэд маань хоёр асуудлыг тавьсан байж байгаа.

Ялангуяа Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын иргэд маань Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг явуулж өгөөч гэдэг асуудал тавьж байна.

Ханбогд сум 20 мянган хүн амтай, Цогтцэций сум бас 20 мянган хүн амтай, Дорноговь аймгийн Замын-Үүд сум 30 мянган хүн амтай гээд маш олон одоо хүн амтай болж байна.

Цаашдаа ч гэсэн энэ боомт дагасан суурьшлын бүсүүд бас хүн ам нэмэгдэх, хүн амын төвлөрөл бий болох ийм эрсдэл бий болж байна.

Тийм учраас Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг энэ хаврын чуулганаар явуулж өгөөч гэдэг асуудлыг явсан газрын Ханбогд, Цогтцэций сумын иргэд маань хэллээ гэдгийг бас дамжуулж байна.

Тийм учраас Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хаврын чуулганаар явуулж өгөөч ээ гэдгийг л хэлмээр байна.

**Хоёр дахь асуудал.** Энэ байгалийн давагдашгүй хүчин зүйл, давагдашгүй байдалтай холбогдуулаад олон иргэд маань малгүй болж байна.

Тийм учраас малчид маань малжуулах ажлыг зохион байгуулж өгөөч ээ.

Төсвийн тодотгол хийдэг бол тодотгол хийгээд одоо энэ 7, 8 сард энэ байгалийн давагдашгүй хүчинд өртөж малгүй болсон иргэдийг малжуулах ажлыг зохион байгуулж өгөөч ээ гэдэг ийм асуудлыг бас уламжилж өгсөн байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг энэ хаврын чуулганаар хэлэлцээд төсөвт тодотгол хийдэг бол тодотголд хийгээд ингээд энэ малыг нь худалдаж аваад 8, 9 сард малгүй болсон иргэдийг малжуулах ажлыг зохион байгуулбал илүү их үр дүнтэй юм болов уу гэдэг асуудлыг тавьж байлаа гэдгийг дамжуулмаар байна.

**Гурав дахь асуудал.** Энэ говьд усны асуудал байж байна.

Ялангуяа “Хэрлэн-Тооно” төсөл төслийн асуудал хэр түвшинд явж байгаа



юм. Техник, эдийн засгийн үнэлгээ хийгдсэн юм уу.

Үнэхээр тэр ус татах маршрут нь гарсан юм уу, гараагүй юм уу, хөрөнгө мөнгөний асуудал нь шийдэгдсэн юм уу, шийдэгдээгүй юм уу гэдэг асуудлыг бас тодорхой болгож өгөөч ээ.

Тийм учраас хаврын чуулганаар Байгаль орчны яам, Уул уурхайн яам, Засгийн газар мэдээллээ ард иргэдэд тавьж өгч, энэ усны асуудал ямар түвшинд байгаа гэдэг мэдээ мэдээллийг ард иргэдэд өгөөч ээ гэдэг асуудлыг тавьж байна лээ.

Өнөөдөр говьд олон үйлдвэрүүд ажиллаж байна. Олон баяжуулах болон боловсруулах үйлдвэрүүд бий болж байна. Олон ажлын байрууд бий болж байна.

Монгол Улсын эдийн засгийг ер нь цаашдаа энэ говийн бүс л чирч явах юм билээ.

Тийм учраас цаашдаа бид уурхайн бүтээгдэхүүнээ аль болохоор баяжуулаад, боловсруулаад гаргая гэж хүн болгон ярьдаг.

Тийм учраас цаашдаа бид усны асуудлыг шийдэхгүй бол говьд цаашдаа энэ үйлдвэрийн асуудал, уурхайн асуудал, ялангуяа цөлжилттэй тэмцэх асуудал нэлээн хүндрэх ийм эрсдэл бий болж байна.

Тийм учраас энэ усны асуудлыг яаралтай шийдэх, ялангуяа усны асуудал ямар түвшинд явж байгаа юм бэ гэдэг асуудлыг энэ хаврын чуулганаар оруулж

ирээд мэдээ мэдээллийг нь ард иргэдэд өгөх зайлшгүй шаардлагатай байна.

Тэгээд энэ гурван асуудлыг энэ хаврын чуулганаар хэлэлцэж өгөөч ээ л гэдэг асуудлыг ард иргэд маань тавьж байна лээ. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Гишүүд үг хэлж дууслаа.

Сая хөдөө орон нутагт ажиллаж байхад манай Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн олонхын бүлгийн дарга, Гочоогийн Ганболд гишүүн, Засгийн газрын гишүүдтэй хамт ажиллаж байхад малчид, иргэдийн зүгээс асуудал тавьсан.

Ер нь малчидтай холбоотой улсууд энэ дээр анхаарч ажиллаж байгаа.

Түүнээс гадна тэр 1 сая га газар хайгуулын лиценз, тусгай зөвшөөрөл өгчихсөн байна.

Зарим аймгийн нутаг дэвсгэрийн 25 хувийг тусгай зөвшөөрөл олгоод өгчихсөн байна.

Хуулиараа 15-аас 1 суманд хэтэрдэггүй гэх мэтчилэн олон хууль зөрчсөн байна.

Аймаг, орон нутаг нь жишээлбэл Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын нутагт 1 сая га газар өгчихсөн байна гэсэн ийм тодорхой асуудлууд яригдсан.

Үүнийг шалгаж үзээд 1 сая га газар биш, тэр чинь 34 мянга 600 га газар нэг аймагт.

Тэгэхдээ нийт улсын хэмжээнд 1 сая га газар хайгуулын зөвшөөрөл өгөгдсөн байсан.

Тэгэхдээ тэр нь аймаг, орон нутаг нь энэ гол ус, худаг ус, шандын говийн Баянбүрдийн эх нутаг өгч болохгүй ээ гээд бичиг өгөөд байхад ингэж өгсөн асуудлыг Ашигт малтмалын хэрэг эрхлэх газарт мэдэгдээд энэ хайгуулын зөвшөөрлүүдээ цуцалсан байгаа.

Хүрэн толгой, Сухамтын худаг гэдэг хоёр газрын хайгуулын лицензийн асуудлыг цуцлах мэдэгдлийг холбогдох газруудад хүргүүлсэн гэж мэдээлэл хийсэн.

Тэгээд үүн дээр Уур уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар анхаарал тавьж ажиллаад, судлаад манай Улсын Их Хурлын гишүүд, холбогдох хүмүүст хариу өгнө.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орно.

---

**Гурав. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

---

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд гишүүн танилцуулна.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай асуудлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Их Хурал тогтоодог.

Үүний дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос 2024 оны 03 сарын 04-ний өдөр ирүүлсэн санал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хороо уг асуудлыг 2024 оны 03 сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 9.1 дэх хэсэгт Монгол Улсын Их Хурал орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийг сонгуулийн жилийн 05 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө товлон зарлаж санал авах өдрийг тогтооно.

Мөн зүйлийн 9.2 дахь хэсэгт орон нутгийн хурлын ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн 10 дугаар сарын эхний хагасын аль нэг ажлын өдөр байна гэж заасны

дагуу 2024 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг 2024 оны 04 сарын 30-ны өдрөөс эхлэн товлон зарлахаар, санал авах өдрийг 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдөр байхаар Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэхэд Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, С.Бямбацогт, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн нар асуулт асууж, хариулт авч, саналаа илэрхийлсэн болно.

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Эрхэм гишүүд ээ,

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье. Тогтоолын төслийг тараасан байгаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлтэй холбогдуулж

асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Ц.Туваан:** Цуг юм уу? Тийм ээ.

Энэ бас хөдөө орон нутагт, иргэдийн, ялангуяа энэ суманд амьдарч байгаа хүмүүсийн их сонирхож байгаа асуулт л даа.

Тэгээд өмнө нь бид бүхэн чинь Орон нутгийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах энэ хугацааг чинь жил байсныг 6 сар болгосон. Тэгээд хэлэлцээд ер нь бараг шийдэгдчихсэн гээд л явсан. Тэгээд энэ чинь больчихсон юм уу? Энэ талаар нэг тодорхой албан ёсны хариултыг өгөөдхөөч.

Сонгуулийн ерөнхий хороо ч гэсэн бас хэрвээ одоо больсон бол үүнийгээ олон нийтэд зарлаж хэл ээ. Одоо орон нутгийн сонгуулийн хуульд өөрчлөлт оруулахгүй болсон гэдгээ. Энэ хугацааны болон хэлэлцүүлгийн ямар нэгэн асуудал үүссэн гэдгээ яахгүй бол.

Энэ дээр тодорхойгүй зүйл их байгаа учраас малчид, иргэд, бүр сумдын удирдлага, мэдээлэлтэй хүмүүс ч гэсэн энэ дээр хариулт нэхээд байна шүү. Энэ дээр та бүхэн нэг хэлээдхээч.

Хоёрдугаарт нь, энэ сонгуулийн санал авах өдрөө энэ удаагийнх дээр гурав дахь өдөр болгоод юм уу, хуучин явж байсан жишгээрээ хийж болохгүй юм уу?

Орон нутгийн сонгуулийн тухай хууль Их Хурлын сонгуулийн тухай хуулиас ондоо. Эрт намар хүйт орчихдог. Нүүдэл суудал болж байдаг. Ирц маш багасдаг. Тийм.

Тэгэхээр дахиад тав дахь өдөр хийгээд нөгөө бид хэдийн яриад байгаа юм бас энэ чинь залуучууд оролцохгүй байх, дараалсан амралтын өдрүүд олон байх гээд энэ зүйлийг. Одоо хэдүүлээ нэг их улс төржөөд байлгүй энэ орон нутгийн сонгуулийн хууль дээрээ өөрчилчихвөл яасан юм бэ? Хугацаа, өдөртэй холбоотой.

Тэгээд ер нь одоо хөдөө орон нутагт, ялангуяа **20 аймгийн 220 сум** гэж байсан. Энэ **зудтай** нөхцөл байдалд энэ бусад асуудал манатай л байна даа.

Тэгээд Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс ээлжит бус чуулганы хуралдаан зарлаж, Монгол Улсын Их Хурлын гишүүд өргөсөн тангаргийнхаа дагуу ард иргэддээ тулгамдаад байгаа **“төмөр, шилэн зуд”**-ынхаа асуудалд онцгой анхаарлыг маш хурдан хандуулахгүй бол одоо он давах гээд ядарчихсан, үе нь суларсан мал, малаа дагасаар байгаад ядаргаанд орчихсон, сэтгэл санааны хямралд орчихсон малчдын асуудал маш хүнд байна шүү.

Энэ дээр Ардчилсан намын бүлгийн гишүүдээс

- **“Малчны зээлийг тэглэх”** асуудлыг өргөн барьсан,
- **“Малын хөлийн татварыг хойшлуулах”** асуудлыг өргөн барьсан.

Дээрээс нь бид бүхэн Улсын Их Хурал дээр шийдвэр гаргаад энэ **“Хотын сэргэлт”**, **“Хөдөөгийн сэргэлт”** гээд хотоос хөдөө рүү шилжих шилжилт нүүдлийн асуудлыг ярьж байгаа.

Энэ чинь яг эсрэгээрээ болох гээд байна шүү.

2000 оны зудад малаа алдсан иргэдийн их нүүдэл. Хоёр дахь их нүүдэл одоо эхлэх гэж байна.

Сүхбаатар аймаг, Дорноговь аймаг хүнд газруудаас яваад эхэлчихлээ. Нүүдэл.

Тэгээд нөгөө хотын асуудлыг хүндрүүлээ гээд, утаа, түгжрэл гээд яриад байдаг асуудал чинь бид нарт бүр нүүр тулаад ирчихлээ.

Тэгэхээр энэ дээр тангараг өргөсөн Их Хурлын гишүүд одоо анхаарал хандуулж ажиллах болоогүй юм уу?

Малчид маань юу хүсэж байна гэхээр төртэй улс Засгийн газартай юм бол нэг бодлогын томоохон арга хэмжээ аваач ээ. Нэг шуудай хивэг, нэг боодол өвс, нэг жоохон юм чинь үнэхээр аманд ч үгүй, хамарт ч үгүй байна.

Тэгэхээр энэ бодлогын том асуудал руугаа орооч ээ гэдэг ийм хүсэлтийг тавьж байна.

Үүн дотор энэ **“Малжуулах хөтөлбөр”** гэдэг юмыг нэг дорвитойхон хийгээдхээч ээ. Аргацаасан нэг жоохон, цөөхөн байдлаар хийх биш улсын төсөв дээр шаардлагатай бол тодотгол хийж байгаад энэ асуудал руу санхүү тавьж

байгаад “Малжуулах хөтөлбөр”-ийг өргөн цар хүрээтэй хийхгүй бол амьжиргаа, малаа алдсан, хотоо харлуулсан малчид чинь нэг приустэй, нэг портертойгоо Улаанбаатар хотод.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Нямаагийн Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** Ц.Туваан гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт, нэг жилтэй холбоотой, 6 сартай холбоотой Сонгуулийн хуулийн зохицуулалтыг ярьсан.

Бид Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлт, тэрийг дагаад Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлттэй адилтгаад тэр үзэл баримтлал, агуулгуудыг тусгасан Орон нутгийн сонгуулийн хуулийг шинэчилж найруулаад Улсын Их Хурлаар хэлэлцүүлсэн.

Үндсэндээ бүгдийг нь хэлэлцээд Байнгын хороодоор дамжаад дэмжчихсэн.

Хамгийн сүүлд санал хураагаад эцэслэж алх цохих асуудал үлдсэн байсан.

Энэ хууль дотор сонгууль болохоос 6 сар, одоогийн хуульд нэг жилийн өмнө, нэг жилийн дотор өөрчлөлт оруулж болохгүй ээ гэсэн заалт байсан бол тэр бид нарын нөгөө хэлэлцүүлээд үндсэндээ батлаад алх цохихоос бусад нь гүйцчихсэн байсан хууль 6 сар гээд яг өөрийн чинь ярьж байгаа шиг ингээд оруулчихсан байсан.

Тэгээд хамгийн сүүлд цаг хугацааны хувьд. Би одоо 10 сарын 30-н шиг санаж байна. Сүүлийн өдөр байсан. Тэр өдөр ирц хүрээгүй. Яг тэр асуудал дээр хүргээгүй гэж би бодоод байдаг юм.

Яагаад гэвэл тодорхой гишүүд ийм байхгүй ээ, хуучнаараа явна аа, цөөнх тийм бас зарим саналтай хүмүүс байсан. Нэр усыг нь, бүлгийг нь дурдаад яах вэ.

Тэгээд тэр хуулиа бид баталж чадаагүй. Тэгээд жилийн дотор өөрчилж болохгүй гэсэн заалт маань зөрчигдчих гээд. Тэр өдрөөс хойш тэгээд хэлэлцэлгүй ингээд орхигдсон, батлагдаагүй.

Тэр бид нарын ярьсан юмнууд байхгүй. Хуулиар боломжгүй болчихсон гэдгийг бүр тодорхой хэлчихье.

Тэгэхээр энэ удаа 10 сарын 11-нд хийе гэж бид нарын санал болгож байгаа Орон нутгийн сонгуулийн хууль хуучин хуулиараа явна.

Тэр хуулийн 82.1-д орон нутгийн хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрөөс өмнөх нэг жилийн хугацаанд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тухай хууль батлах, түүнд өөрчлөлт оруулахыг хориглоно гэсэн заалт байгаа учраас яг энэ хуулийнхаа хүрээнд өнөөдөр бид энэ асуудлыг Улсын Их Хуралд Байнгын хороогоор хэлэлцээд оруулж ирж байгаа юм.

Тэгээд одоо энэ дээр эргэлзэж, тээнэгэлзээд яах юм бол, шинэ хуулийн хууль хуучин хуулиар явах юм болов уу гэх юм байхгүй.

Одоо яг хуучин хуулиараа урьдын адил орон нутгийн сонгууль явагдана гэдгийг тодорхой хэлчихье. Энэ Их хурлын индэр дээрээс.

Хоёр дахь асуудлын хувьд хуучин. Бид бас энэний түрүүчийн юуг харсан л даа. Яг хэд дэх өдөр явж байж вэ гээд. Орон нутгийн сонгууль бас 5 дахь өдөр явж байсан юм билээ. Эхний хагасын багтаан нэг ажлын өдөр байна гэсний дагуу хийж явуулсан.

Тэгээд тэр дагуу энэ удаа ч гэсэн 10 сарын 11-ний өдөр гэж саналаа оруулсан. Үүнийг Байнгын хороон дээр гишүүдийн олонх дэмжээд ингээд Их Хуралд орж ирж байгаа юм.

Зүгээр дахин дахин яриад байгаа нэг асуудал бол 5 дахь өдөр болохоор л залуучууд орохгүй юм шиг ингээд дахин дахин яриад байх юм.

Тэгээд миний санаа зовж байгаа юм юу болохоор бараг тэрэнд одоо уриалаад ч байгаа юм шиг. Тэрний оронд хэд дэх өдөр болох нь хамаагүй, хөгшин залуу нь хамаагүй монголчууд иргэд, сонгогчид маань төрийн сонгуульдаа орон нутгийнхаа сонгуульд маш идэвхтэй оролцох ёстой шүү гэж ярих нь илүү хэрэгтэй болов уу л гэж бодоод байгаа юм.

Одоо тав дахь өдөр болохоор залуучууд би бол орох болов уу л гэж бодож байгаа шүү дээ. Ер нь залуучууд маань идэвхтэй байгаа. Ялангуяа Үндсэн хууль шинээр батлагдсан оролцооны бололцоо нэмэгдэж байгаа энэ үед ялангуяа залуучууд сонгуульдаа маш идэвхтэй оролцох байх гэж найдаж тэгж бодож л явж байгаа. Тийм.

**Г.Занданшатар:** Ц.Туваан гишүүн тодруулж асууя.

**Ц.Туваан:** Тэгэхээр энэ дээр яах вэ, ер нь сая бид нар Мартаар 8, 9, 10 амралтын өдөр байлаа л даа.

Тэгэхээр энэ дээр хүмүүс бас сэтгэл зүй, ард иргэдийн маань сэтгэл зүй бол энэ дараалсан олон хоног амрах гэдэг дээр байгаа шүү дээ. Хэн ч гэсэн. Хүн л юм чинь.

Тэгэхээр энэ дээр заавал залуучууд гэж яриад байгаа нь бас буруу байж магадгүй. Тэгэхдээ л ер нь хөгшин залуу гэлтгүй иргэдийнхээ сонгуульд оролцох итгэл, оролцооны идэвх, энэ бодитой асуудлыг хэдүүлээ ярьчихвал яасан юм бэ. Энэ дээр нэг их улс төрийн намууд гээд улс төржөөд тийшээ ийшээ гэхээсээ илүүтэй намрын сонгуулийн ирц мууддаг. 50 хувь хүргэх гээд. Ялангуяа Улаанбаатар хотод сандардаг шүү дээ, сүүлдээ.

Тэгэхээр энэ дээр хэдүүлээ бас нэг яг ажлын долоо хоногийн таван өдрийнхөө дунд нь ч юм уу тавиад.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Энэ тов тогтоох асуудал. Ц.Туваан гишүүн худлаа ярихгүй байхыг хүсэж байна.

Тодруулгад хариулт авахаас гадна та байна шүү дээ малчдын холбоотой ямар ч хууль, тогтоолын төсөл санаачлаагүй. Энэ дотор байна шүү дээ, тэр малчдын зээлийг тэглэх тухай ямар ч зүйл.

Энэ жагсаалтад байхгүй. Өргөн баригдаагүй. Өргөн баригдаагүй юмыг өргөн баригдсан гэж худлаа ярьж болохгүй. Худлаа ярьж болохгүй. Өргөн өргөн баригдсан ганц ч зүйл байхгүй. Хэнд барьсан юм. Би аваагүй.

Тэр чинь тов тогтоолгохоор өгсөн юм байгаа биз. Өргөн баригдсан гэдэг чинь надад өргөн баригдаагүй. Та битгий. Бичлэгээ үз. Өргөн баригдсан гэж худлаа ярьж болохгүй.

Дараагийн гишүүн. Нямаагийн Энхболд гишүүн тодруулгад нь хариулт өгчих.

**Н.Энхболд:** Тийм. Одоо яах вэ, тэгээд хэрэв энэ асуудал олонхоороо ингээд одоо Байнгын хороогоор орж ирж байгаа энэ өдөр дэмжигдэхгүй болбол тэгээд дахиад ярилцах л хэрэг гарна шүү дээ. Одоо бид Байнгын хорооны саналаар санал хураах ёстой. Дэмжигдээд явчихвал тийм бололцоо байхгүй.

Дэмжигдэхгүй бол дахиад гарах бололцоогоор нь тэр үед саналаа гаргаж болно. Ийм л дэгээрээ л явж байгаа юм. Тийм.

**Г.Занданшатар:** Дашдондогийн Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** Ингээд та бүгдийн амар амгаланг айлтгая.

Их хүнд ч өвөл болж байна, хаваржилт ч нэлээн хүндэрчихсэн байна. Үүнийг дараа тусад нь ярина. Ярих ёстой юм дээрээ.

Энэ сонгууль их чухал. Энэ бас ардчиллаар иргэд өөрийнхөө удирдах

сум, орон нутаг, Улсын Их Хурал ингээд л сонгоно л доо.

Тэгэхдээ сүүлийн үед нэг ийм юм яваад байна. Хаанаас нь, хэнээс нь гараад байгаа бодлого юм. Яагаад ингэж олон түмнийг аль болохоор л бага оролцуулах гэсэн.

Нэгэнт л сонгууль зарлаад явуулж байгаа болохоор сонгогчдын ихэнхийг нь оролцуулах ийм л бодлого явах ёстой шүү дээ. Тэгж байж нөгөө хүлээн зөвшөөрөгдсөн удирдлага байна. Тэгэхгүй бол нөгөө үймээн, хөдөлгөөн, дургүйцэл гардаг. Үүнийг та нар анхаарах ёстой.

Бид бүхэн Улсын Их Хурлын нөхөн сонгууль гэхэд 50 хүрэхгүй хувьтай нь явуулаад л тэгээд л явсан шүү дээ. Түүндээ бүр амтшаад байгаа юм уу. Энэ чинь ямар юманд хүргэх вэ гэдгийг та нар бас бодох ёстой.

Сая манай Ц.Туваан гишүүний яриад байгаа зөв л дөө. Ер нь манайхны яриад байгаа зүйл шүү дээ. Ер нь алсыг харсан юмаа л бид нар ярьдаг. Гэтэл өнөө маргааш энд өөрсдөө хариуцлага тооцох боломжийг аль болохоор багасгасан ийм зүйлийг хийгээд байх юм. Энэ дээрээ нөхдүүд анхаар аа.

10 сарын 11-ний өдрийг яагаад сонгосон юм бэ? 10 сарын 20-оор, 30-наар байж болохгүй юу. Наашаа нүүдэл суудал болдог. Бас өвөлжөө, хаваржаа, намаржаандаа буучихсаны дараа энэ сонгуулийн ажлыг явуулах нь зөв өө.

Нөгөө талаар одоо бас энэ Улаанбаатар хотод утаа нь дийлдэхээ байсан. Тэр утаа нь ч гэсэн гарч байна.

Тэрийг харж байгаа ч гэсэн саналаа өгөх нь зөв байх. Ийм юмнуудыг бодолцож ийм үр дүнтэй ажил хийхгүй бол татвар төлөгчдийн мөнгийг тэгээд нэг сонгуульд зүүсэн нэр зүүгээд нэг авторитар орнуудын тэр чиглэл рүү явдаг ийм юм руу яваад байна. Өдрөөс өдөрт. Үүнийг та нар юу гэж бодож байна вэ? Энэ өдрийг яаж сонгосон юм бэ? Хэн сонгосон юм?

Гурав дахь өдөр яагаад байж болдоггүй юм бэ? Энэ чинь одоо бас улс орны маш том чухал ажлуудын нэг шүү дээ. Тэгээд амралтын гурван өдөр болоод нөгөө хүмүүс чинь хөдөө гадаа явчихдаг. Энэ бол үнэн шүү дээ. Бид нарын амьдралын байдал ийм л байгаа.

Тэгэхээр аль болохоор сонгуульдаа хүмүүсийг олноор нь оролцуулахын тулд ажлын өдөр гэж байгаа бол гурав дахь өдөр тавьчихаж болно. Ийм боломжтой юу гэсэн ийм хэдэн асуултууд байна.

**Г.Занданшатар:** Нямаагийн Энхболд. Төрийн байгуулалтын байнгын хороон дарга.

Яагаад энэ өдрийг сонгосон юм бэ гэж байна.

**Н.Энхболд:** Хоёр асуулт тавилаа. Яагаад 10 сарын 20-доос ч юм уу, хойхноор тавьж болоогүй юм бэ гэж нэгдүгээр асуудал.

Энэ дээр бас одоогийн хуульд ингээд заачихсан байгаа юм аа, Д.Ганбат гишүүн ээ.

Бид өөрчлөх гээд чадаагүй. Нэг хэсэг маань эсэргүүцээд, хуралдаанд

оролцолгүй, ирц бүрдүүлэхгүй байж байгаад хуучнаар үлдээчихсэн.

Одоо хүчин төгөлдөр байгаа хуульд маань 9.2-т нь орон нутгийн хурлын ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн 10 дугаар сарын эхний хагасын аль нэг ажлын өдөр байна гээд.

Ингээд 10 сарын 15-наас өмнө хийгээд хуульд заачихсан юм. Тэгээд тэрнийх нь дагуу бид ярьж байгаад үүний түрүүчийн 2020 оны орон нутгийн сонгууль бас яг 10 дугаар сарын эхний хагасын хамгийн сүүлийн ажлын өдөр буюу бас тав дахь өдөр таарч байсан юм билээ.

Тэрүүгээр жишиг аваад тэгээд эхний хагасын хамгийн сүүлийн тав дахь өдөр нь 11-н байсан. Тэрүүгээр санал оруулсан.

Энэ дээр Байнгын хороогоор ярьж байгаад л олонхоороо шийдчихсэн ийм асуудал байгаа юм.

Түрүүчийнх нь хоёр дахь асуултад нь би түрүүн Ц.Туваан гишүүний асуултад хариулахдаа Байнгын хороон дээр яригдсан зүйлээ хэлчихсэн дээ. Тийм. Давтаад яах вэ дээ.

**Г.Занданшатар:** Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

**Д.Ганбат:** Ер нь ардчилсан системийг аваад бид нар 30-аад жил явж байна.

Ингээд үе үеийн сонгуулиудыг хараад байхад ирц нь багасаад байдаг. Ер нь орон нутгийн сонгуулиудын ирц ямар



байсан бэ? Хэрвээ энэ 50 хувьдаа хүрэхгүй бол хариуцлагыг нь хэн хүлээх юм бэ?

Сүүлийн үеийн тэр сонгуулийн ирцүүдийг нэг сонсчихмоор байх юм. Ирц нь ямар байсныг. Ихсээд байсан юм уу, багасаад байсан юм уу?

**Г.Занданшатар:** Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран хариулъя. 3 номер.

**П.Дэлгэрнаран:** Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

2020 оны орон нутгийн ээлжит сонгуулийн дундаж ирц улсын хэмжээгээр 64 хувь байсан.

2020 оны Улсын Их Хурал орон нутгийн сонгууль дээр ирцийн хувьд жижиг буюу цөөн сонгогчидтой багууд дээр санал тэнцэх асуудлууд гардаг. 190 хэдэн сонгогчидтой, 200 руу бараг хүрэхгүй сонгогчидтой газруудад яг санал тэнцэх асуудал байдаг.

Ийм цөөн тоотой сонгогчидтой засаг захиргааны нэгжүүд дээр болж байгаа сонгуулиудын ирц маш их өндөр байдаг. Төвлөрсөн газруудын Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн ирц харьцангуй бага байгаа.

Тэгээд тэр багууд дээр болж байгаа, хөдөө орон нутаг сум багууд дээр болж байгаа сонгуулийн ирц.../микрофон хаагдсан/

**Г.Занданшатар:** Ирц хүрэхгүй бол хэн хариуцлага хүлээх юм бэ гэсэн байна.

Нямаагийн Энхболд дарга хариулъя.

**Н.Энхболд:** Сая П.Дэлгэрнаран даргын хэлсэн сүүлийн хувь хэмжээ микрофон нь хаагдаад, хугацаа нь дуусчхаад сонсогдсонгүй бололтой.

Ерөнхийдөө орон нутгийн сонгуульд хэсгүүд дээр ирц 80-аас 90 хувьтай, зарим газар 100 хувь хүрдэг гэсэн ийм тоо хэлсэн шүү. Үүнийг хэлчихье.

Хэрэв ирц хүрэхгүй бол тэр дээр дахиад санал хураалтууд явуулдаг. Ирц хүрээгүй хэсгүүд дээр нь. Ирц хүрээгүй хэсгүүд дээр.

Хуульд хэрэв ирц хүрэхгүй бол хэн нэгэн хүн хариуцлага хүлээнэ гэсэн заалт хаана ч байхгүй.

Урьд өмнө нь тийм юмнууд гарч байгаагүй. Нэгд. Хоёрт, хууль дээр тийм заалт байхгүй. Ирц хүрээгүй хэсгүүд дээр дахин санал, нэмэлт санал хураалт явуулаад түрүүчийн удаа ирээгүй байсан сонгогч иргэд ирж саналаа өгөөд гүйцээгээд явж байсан ийм л практикаар явж ирж байсан байгаа.

**Г.Занданшатар:** Сандагийн Бямбацогт гишүүн.

**С.Бямбацогт:** Гишүүдийнхээ амгаланг айлтгая.

Тэгээд чуулган завсарласан хугацаанд орон нутагт ажилласан. Говь-Алтай аймаг, Завхан аймаг, Увс аймаг, Ховд аймгийн олон иргэд, сонгогчидтой уулзаж санал бодлыг нь сонсож, бүсчилсэн хөгжлийн бодлого, үзэл

баримтлалыг танилцуулж нэлээд уулзалтууд хийлээ.

Ингээд уулзаад явж байх явцад иргэдийн тавьж байгаа нэг том асуудал бол энэ орон нутгийн сонгуулийг томсгоё.

Та бүхэн улс орныхоо хөгжлийн бодлогыг томоор нь хардаг, бүс нутгийн хөгжлийн бодлогыг хамтраад хийж хэрэгжүүлэх ийм томсгосон тойрогтой болж байна. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх энэ санал санаачилга гаргалаа. Үүнийг дэмжиж байна.

Яг үүнтэй адилхан бас орон нутгийн сонгууль чухал. Нутгийн өөрөө удирдах ёс, тухайн 4 жилийн хугацаанд аймгаа хэн удирдах вэ, сум орон нутгаа хэн удирдах вэ. Тэр удирдах хүмүүс нь мэдлэгтэй, чадвартай, сум орон нутгийг төлөөлөх тийм сэтгэлтэй байгаасай, баймаар байна.

Өнөөдрийн энэ сонгуулийн тогтолцоо чинь ерөөсөө жалга довны, нэг багаас 100 хүнээс, 200 хүнээс сонгогддог. Тэнд хэн олон ах дүүтэй, хэн олон хамаатан садантай нь сонгогддог ийм л тогтолцоо байгаад байгаа юм.

Тэр сумаасаа сумын нийт төлөөллийг сонгоод сум дундаасаа мэдлэгтэй, чадвартай, сум орон нутгаа гэсэн сэтгэлтэй нь сонгогддог болмоор байна. Ингэх юм бол сум орон нутаг, аймаг хөгжмөөр байна. Энэ асуудлыг шийдэж өгөөч ээ гэдэг асуудлыг их ярьж байна.

Тийм болохоор Орон нутгийн сонгуулийн хуулиа бид өөрчилж

болохгүй юу? Орон нутгийн сонгуулийн хуулиа.

Бид Үндсэн хуульдаа 2019 онд өөрчлөлт хийсэн. Монгол Улсын хөгжлийн бодлогыг томоор нь харах, төрийн бодлого том байх, тогтвортой байх, тодорхой байх заалтууд оруулсан.

Үүнийг хэрэгжүүлэх гэж төрийн эрх барих Улсын Их Хурлаа сонгуулийг томсгосон тойргоор бүсчилж явуулах болсон.

Яг үүнтэй адилхан орон нутгаа ч гэсэн томоор нь хардаг болмоор байна. Томоор нь харах тийм сэтгэлтэй чадвартай хүмүүс сонгомоор байна гэдэг асуудал яриад байна л даа.

Тийм болохоор юу гэдэг юм Их Хурал нь болчихлоо, орон нутаг нь одоо хамаагүй ээ гээд хаячихмааргүй байна л даа. Бидэнд бас бололцоо байгаа.

Сонгууль болохоос 6 сараас өмнө Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулж болно. Ингээд үзэх юм бол одоо юу гэдэг юм 05 сарын 01-нээс өмнө бид Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах бололцоо байна.

10 сарын 15 гэж товлож байгаа бол 04 сарын 15-наас өмнө. Өнөөдөр 03 сарын 15. Нэг сарын хугацаа байгаа байхгүй юу. Энэ хугацаандаа сонгуулийн хуульдаа өөрчлөлт оруулаад.

Улсын Их Хурлын сонгуулийн хуульд чинь би сонгуулийн зардлыг бууруулах сайн заалт орсон. Гадаадад байгаа иргэдийн саналыг авах сайн заалт орсон. Нөгөө жендэрийн тэгш байдлыг хангах энэ заалтууд орсон байж байгаа.

Ийм сайн заалтуудаа оруулмаар байна. Сонгогчдын нэрсийн жагсаалт ил тод байх энэ бас тусгагдсан байгаа.

Заавал маргаантай, мэтгэлцээнтэй, хардлага зэрлэг дагуулсан заалтууд биш иргэд сонгогчдын хүсэж байгаа, ялангуяа нутгийн өөрөө удирдахаасаа бэхжүүлэх, тэгээд сум, орон нутгаа, аймгаа гэсэн сэтгэлтэй хүмүүсийг сонгох, чадвартай хүмүүсийг сонгох ийм томсгосон тойргийн Их Хуралд оруулж байгаа энэ зарчимтай адилхан орон нутаг ийм л болгох энэ тогтолцоог оруулаад уг нь хуулиа сайжруулчихмаар байна.

Энэ дээр боломж байна гэж харах. Хуулийг бид хуулиар өөрчилж болно. Хуулийг өөрчлөхөд хамгийн багадаа сарын хугацаа бидэнд байж л байна л даа. Тэгээд энэ дээр боломж бололцоо юу байна вэ?

Төрийн бодлого маань том баймаар байна, тодорхой баймаар байна, тогтвортой баймаар байна. Орон нутгийн өөрөө удирдах ёс ч гэсэн төлөөлөх хүмүүс маань бас том баймаар байна.

Энэ рүү анхаарсан юмыг л хийж өгөөч ээ. Хийж өгөөч гэсэн саналыг иргэд маань тавиад байна л даа. Үүнийг л нэг гарц шийдэл гаргачихмаар байх юм. Бас Төрийн байгуулалтын байнгын хороонд бас ярьсан.

Дээрээс нь сонгуулийн зардлыг бууруулмаар байна. Улсын Их Хурлын сонгууль чинь зардал нэлээн буурахаар болчихсон шүү дээ. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах. Орон нутгийн сонгуулийн хуульд чинь 20-хон хувь байж байгаа.

Бид Их Хурлын сонгуулийн хуульд 30 хувь, 40 хувь болгоод хийчихсэн. Ийм уг нь сайн заалтуудыг л тусгаад явчихмаар байдаг.

Урьд нь ирц хүрээгүй юм бол, бэлэн болчихсон, хэлэлцчихсэн юм бол нэмээд ганц хоёрхон заалт оруулаад явчих.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Нямаагийн Энхболд Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга хариулья. Маш чухал асуулт байна.

**Н.Энхболд:** Саяын С.Бямбацогт гишүүний ярьсан зүйлүүдийг л оруулсан. Орон нутгийн сонгуулийн хууль хийгээд бид нар яриад, хэлэлцээд, дэмжээд, тэгээд баталгүй орхичихсон юм л даа. Яг л саяын юмнууд байж байгаа.

Тэгээд Их Хурал өөрөө ингээд л шийдчихсэн шүү дээ.

Тийм болохоор бид нар яах аргагүй одоо хүчин төгөлдөр байгаа хуулийнхаа хүрээнд л Байнгын хороо угаасаа хугацаатай болохоор нь хэлэлцээд оруулаад ирж байгаа юм.

Яах вэ, эрх зүйн дүгнэлт гаргаад, энэ хуульд байгаа юмыг “жил” гэснийг нь “6 сар” болгож болно. Энэ нь өөрөө Үндсэн хууль зөрчсөн үйлдэл болохгүй гэж үзвэл саяын С.Бямбацогт гишүүний хэлсэн шиг ийм зай байна. Нэг сарын.

Бид ажлын хэсгээс Байнгын хороонд оруулахдаа одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиа бариад л 10 сарын 01, нэг жилийн дотор өөрчлөлт оруулж

болохгүй гэсэн учраас тэр хугацаанд нь таарсан хуулиараа яваад л ирсэн.

Тэгээд одоо барьж байгаа хуулийнхаа дагуу ингээд гарчихсан юм байгаа.

Би ганцаараа тэрийг нь одоо дахиад **Орон нутгийн сонгуулийн хуульд “нэг жил гэснийг нь 6 сар”** гэж өөрчлөөд баталчихад хууль зөрчихгүй, сүүлд нь Үндсэн хууль зөрчсөн хэрэгт орохгүй гэж. Хэлж мэдэхгүй байна л даа.

Яг л хүчин төгөлдөр байгаа хуульд нь л бариад л ороод ирсэн байгаа юм.

Эрх зүйн дүгнэлт хэрэгтэй болох болов уу даа. Миний харж байгаа, бид нарын ярьж ойлголцсоноор **“жилийн дотор өөрчлөлт оруулж болохгүй”** гэж байхад эд нар өөрчлөлт оруулчихлаа гээд бас нэг асуудал хөндөгдөх ийм эрсдэл нэг талаар, нөгөө талаар боломж нь байгаад байгаа юм. Тийм.

**Г.Занданшатар:** Сандагийн Бямбацогт гишүүн тодруулж асууя.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын Сонгуулийн хуулийг бид Үндсэн хуульдаа оруулаад сонгууль болохоос жилийн өмнө өөрчлөлт хийж болохгүй гээд Үндсэн хуульд оруулчихсан. Үүнийг бид яагаад ч хөдөлгөж чадахгүй. Үндсэн хуулиа өөрчилж байж хөдлөхөөс өөр аргагүй.

Орон нутгийн сонгуулийн хуулийг жилийн өмнө гэдэг бол орон нутгийн сонгуулийн хуульд байж байгаа.

Тийм болохоор бид хуулийг хуулиар өөрчлөөд 6 сарын өмнө болгоод

6 сарын өмнө сайжруулсан заалтууд, иргэдийн хүсэн хүлээж байгаа. Хамгийн гол нь. Нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлбэ. Улсын Их Хурлын сонгуулийн хуульд суусан сайн заалтуудыг л тусгах. Өөр илүү дутуу юм хэрэггүй шүү дээ.

Ийм агуулгаар л иргэд хүсээд байгаа. Үүнийг л уг нь шийдчихвэл зүгээр байгаа юм л даа.

Энэ дээр манай Тамгын газрынхан бас нэг эрх зүйн дүгнэлт гаргах боломжтой юу? Эрх зүйн дүгнэлт гаргаад бид бас нэг хэлэлцээд явчихвал болно.

Улсын Их Хурлын сонгууль нь сайн болчихсон байгаад байна. Үүнтэйгээ адилхан яагаад Орон нутгийн сонгуулийн хууль нь сайн болж болдоггүй юм бэ? Яагаад төрийн эрх барих байгууллага нь сайжраад, орон нутгийн эрх барих байгууллагууд нь иргэдийг төлөөлөх чадамжгүй байдаг юм бэ? Үүнийг адилхан болгочхооч ээ, битгий ялгамжтай хандаач ээ л гэсэн асуудал яриад байгаа юм л даа.

Энэ дээр манай Тамгын газрынхан.

**Г.Занданшатар:** Сонгуулийн ерөнхий хороо Д.Бат-Эрдэнэ дарга хариулах уу. Сонгуулийн ерөнхий хороо.

Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ хариулья. 4 номер.

**Д.Бат-Эрдэнэ:** Орон нутгийн сонгуулийн тухай хуулийн төсөл. Мөн дээрээс нь хуульд өөрчлөлт оруулах

хуулийн төслийн ажлын хэсэгт ажиллаж байсан.

Энэ дээр нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг шууд одоо дүгнэлт гаргах, Хууль зүйн байнгын хорооноос юм уу дүгнэлт гарсны дараа шууд хэлэх боломжтой байх.

Ер нь хууль тогтоомжийн хувьд зөрж байгаа асуудлууд нэлээн бий. Их Хурлын сонгуулийн тухай хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулаад сонгуулийн сурталчилгааны ерөнхий явагдах орчныг өөрчилсөн, зардлыг бууруулах зохицуулалтыг хийсэн боловч 10 сард явагдах орон нутгийн сонгууль нь 2020 онд явагдаж байсан хуучин тогтолцоогоор явах.

Мөн түрүүн гишүүдийн хэлж байсан жендэртэй холбоотой зохицуулалтуудын хувьд ч гэсэн бас ийм зөрүүтэй асуудлууд бас нэлээн хэд хэд үүсэхээр байгаа.

Мөн дээрээс нь Зөрчлийн тухай хууль дээр Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагуулж бас өөрчлөлтүүд.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Тийм. Үндсэн хуульд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж шинээр баталж, нэг жилийн өмнө болохгүй ээ л гэж байгаа. Үндсэн хуулийн заалт.

Одоо Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа.

Тэгэхээр би хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хоёр зүйл асууя гэсэн. Өмнө нь гишүүд асуугаад хариулт гарчихлаа.

Ер нь Монголчуудын эрхэлж байгаа мал аж ахуйн үйлдвэрлэл чинь өөрийн гэсэн ийм онцлог байна шүү дээ. Цаг хугацааны хувьд, улирлын хувьд.

Тийм учраас цаг хугацаагаа нэлээн тооцож үзэх ийм шаардлага байгаа. Үүнийг нь Төрийн байгуулалтын байнгын хороо, ажлын хэсэг анхаарна биз ээ гэж.

Тэгээд үүнтэй холбогдуулаад би юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр зэрэг энэ байгалийн гамшигт үзэгдлийн тоо давтамж, эрсдэл, учруулах хор холбогдол гэдэг чинь айхтар нэмэгдэж байна шүү дээ. Энэ жилийн хувьд зуд турхан гэж аюул болж байна.

Тэгэхээр ер нь уламжлалт мал аж ахуй монголчуудын, Монгол Улсын бүрэн бүтэн байдал, аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа болсон үндэснийхээ өв соёл, уламжлалыг хадгалж авч явж байгаа мал аж ахуйн салбар, малчин түмэн рүүгээ хандсан бодлогоо бид нэн даруй Их Хурал анхаарч үзэх ийм шаардлага байна. Их Хурал дээр Их Хурлын даргын өгсөн чиглэлийн дагуу явагдаж байгаа Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиа энэ хаврын чуулганаар нэн даруй батлах хэрэгтэй байна.

Би үүнийг яагаад хэлээд байгаа юм гэхээр зэрэг ер нь энэ эрсдэлтэй байгаа олон хүчин зүйлүүд байгаа учраас мал аж ахуйн салбарыг бүхэлд нь нэг

цогцоор нь бодлого арга хэмжээ авахгүй болохгүй байна.

Бид өмнө нь **“Монгол мал”** хөтөлбөр, малчдын талаар төрөөс баримтлах бодлогын томоохон бичиг баримтуудыг гаргаж, бодлогын хэрэгжилтийг хангаж ажилласан. Ямар ч байлаа гэсэн арав гаруй жил тодорхой хэмжээнд үүргээ гүйцэтгэсэн. Одоо нэгэнт хугацаа дууссан байгаа учраас дараагийн цогц бодлогыг яаж авах юм бэ? Энэ талаар тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулахгүй бол болохгүй байна.

Хамгийн сайн жишиг бол манай Хэнтий аймгийн Баян-Овоо сум гэж, улсын тэргүүний Баян-Овоо сум гэж. Төрийн үйлчилгээний гавьяат ажилтан н.Баянмөнх агсан даргалж ажиллаж байсан ийм сум шүү дээ.

Тэгээд уламжлалт аравтын тогтолцоонд оруулаад, ингээд малчид хөдөлмөр өө, хөрөнгө өө хоршдог, эв хүчээ нэгтгэдэг ийм сайн жишгийг улс орон даяар бий болгочихсон бэлээхэн жишээ байгаа.

Сая бид очоод уулзахад сумын Засаг даргын Тамгын газрын дарга н.Сарантуяа энэ хүндрэлтэй байдлыг даван туулахад аравтын тогтолцоонд оруулсан малчдын хоршоо, нөхөрлөл үнэхээр том чухал үүрэг гүйцэтгэж байна гэж ингэж бэлээхэн жишээ хэлж байгаа юм.

Тэгэхээр одоо ингээд амьжиргааныхаа эх үүсвэрээс салсан малчдын асуудлыг энэ мал аж ахуйн салбар луугаа яаж хандах юм бэ? Одоо олон малчид, хүмүүс санал онолоо тавьж

байгаа. Энэ мал аж ахуйн салбарыг дэмжих, малчдаа дэмжих, сайн хашаа хороотой байх, хадлан тэжээлээ бэлтгэх хөрөнгө санхүүгийн бага хямд эх үүсвэрийг хангаж өгөөч ээ гэсэн тодорхой саналуудыг хэлж байгаа юм.

Тэгээд энэ бэлчээртэй холбоотой, усжуулалттай холбоотой ийм цогц асуудлууд бий. Энэ **“Хэрлэн-Говь”** төсөл гэж яриад байгаа. Үүнийг эсэргүүцдэг гээд намайг арав гаруй жил над руу гүтгэлээ, дайрлаа.

Энэ чинь эсэргүүцэх биш. Үүнийг чинь бүр хөхиүлэн дэмждэг ийм хүн шүү дээ. Урт нэртэй хууль батлаад Монгол орны ойн сав, усны эх бүрдэх хэсэг, усан сан бүхий газрыг бүгдийг нь хамгаалалтад авсан.

Энэ уул уурхайн компаниудыг усны эхэн дээр сав дагуу ухааж байсан алтны компаниудыг бид бүрэн хэмжээнд.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хариулт авчхаад нэмэх үү? Асуултаа гүйцээчих. 1 минут нэмж.

**Б.Бат-Эрдэнэ:** Одоо бид байгаль орчны багц хуулиудад нь өөрчлөлт оруулаад Монгол Улсын хэмжээнд 21 сав газрын захиргаа чинь төсөвтэй, орон тоотой, зөвхөн тэр голынхоо сав газрын асуудлыг хариуцаад ингээд ажилладаг ийм тогтолцоо руу бид оруулчихсан шүү дээ.

Энэ **“Хэрлэн-Говь”** төсөл яригдахаас өмнө Хэрлэнг тэжээж байгаа Мөрөн, Цэнхэрийн голууд дээр чинь бид усан сангуудыг, хөв цөөрмүүдийг байгуулаад ингээд Хэрлэнгийн чинь

тэтгэх, тэжээх ийм ажлыг чинь бид хийгээд энэ газрын гадаргын усыг чинь хуримтлуулах ийм ажлуудыг хийгээд үр дүнтэй болоод явж байгаа ийм ажил байгаа юм.

Ер нь Хэнтий, Дорнод, Сүхбаатар гурван аймаг 30 жилийн хугацаанд хариуцлагагүй уул уурхайн дайралтаас бид 20 гаруй жил тэмцэж зүтгэж байж нэлээн хамгаалж үлдсэн.

Ингээд одоо уул уурхайн энэ байгалийн баялгийг тонон дээрэмддэг гадна дотнын шуналт бүлэглэлүүд идэвхжээд, нөгөө улигт дайрлага, гүтгэлэг доромжлолоо эхэлчихсэн байна лээ.

**Г.Занданшатар:** Ойлголоо. Энэ ирэх хаврын чуулганаар хэлэлцэх асуудалд орчихсон байгаа.

Ж.Батжаргал гишүүн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга үүнийг анхаарч яаравчлах талаар ажиллаж байгаа.

Тэгээд ер нь яах вэ, энэ мал аж ахуй үйлдвэрлэлтэй холбоотойгоор сонгуулийн хугацаа чинь хөдөө орон нутгийн сонгууль чинь үүнтэй уялдах ёстой талаар цаашдын шийдэл ч гэсэн анхаарах нь зүйтэй.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. /алх цохив/

Одоо санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын

тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт явуулъя. Энэ шинэ танхимд анх удаа санал хураах гэж байгаа учраас туршилтын санал хураалт явуулна.

Тогтоолын төсөл дээр чинь үг, санал нэг явчихлаа. Санал хураалт явуулъя. /алх цохив/ Туршилтын санал хураалт.

Санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглараарай. Ер нь Сонгуулийн ерөнхий хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо энэ асуудлуудыг хэлэлцэхдээ бас холбогдох байгууллагууд, улс төрийн намуудаас санал аваад, харилцан зөвшилцөөд тэгээд өмнөх асуудлууд дээр ч гэсэн тэгж баймаар байгаа юм.

Санал хураалт явуултал Б.Пүрэвдорж гишүүнээр үг хэлүүлнэ ээ гэсэн дэг алга.

Хурал чуулгандаа сууж А.Адьяасүрэн гишүүн ээ. Тэгээд байж байж үг хэлэхгүй бол байхгүй хүнээр яаж үг хэлүүлдэг юм. М.Үнэнбат дарга та хоёрын яриаг би яаж мэддэг юм. Энд үг хэлүүлэхгүй гэж байсан. Б.Пүрэвдорж гишүүн энэ тэр горимын санал гаргаад л үг хэлсэн. Байгаа хүмүүс нь үг хэлсэн.

А.Адьяасүрэн гишүүн байна, Ш.Адьяаа гишүүн байсан гараад явчихсан байна. Санал хураалтад орёе. Норовын Алтанхуяг гишүүн, С.Амарсайхан, Г.Амартүвшин гишүүн, Ж.Батжаргал гишүүн байна. Э.Батшугар гишүүн, Б.Бат-Эрдэнэ гишүүн байна, Ж.Батжаргал гишүүн байна, Б.Бейсен

гишүүн алга байна, Жамбалын Ганбаатар гишүүн байна, Сайнхүүгийн Ганбаатар гишүүн алга байна, Дашдондогийн Ганбат гишүүн алга байна, Хассуурийн Ганхуяг гишүүн байна, Г.Дамдинням гишүүн байна, Б.Жаргалмаа гишүүн байна, Ц.Идэрбат гишүүн байна, Л.Мөнхбаатар дарга, Ц.Сандаг-Очир гишүүн байна, Д.Сарангэрэл гишүүн байна, Б.Саранчимэг гишүүн, Ж.Сүхбаатар гишүүн байна, Ц.Сэргэлэн гишүүн, Д.Тогтохсүрэн дарга байна, Ц.Туваан гишүүн байна, Г.Тэмүүлэн гишүүн байна, Чинбатын Ундрам гишүүн, Одонгийн Цогтгэрэл гишүүн, Ж.Чинбүрэн гишүүн байна, Б.Энхбаяр гишүүн байна, Нямаагийн Энхболд

гишүүн байна, Төмөртогоогийн Энхтүвшин гишүүн байна, Жаргалтулгын Эрдэнэбат гишүүн.

Санал хураалт явуулъя. Байнгын хорооны саналаар “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

22 гишүүн дэмжиж, 53.7 хувийн саналаар батлагдлаа. Тогтоолын төсөл батлагдлаа.

---

**Дөрөв. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай”**  
Улсын Их Хурлын тогтоолын төсөл

---

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна. Индэрт урьж байна.

Бадарчийн Жаргалмаа гишүүн танилцуулна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Жаргалмаа:** Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.4 дэх хэсэгт заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийг хэлэлцээд дараах санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулж байна.

Тогтоолын төслийг  
боловсруулахдаа Сонгуулийн



автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг санал авах, тоолох, дүн гаргах үйл ажиллагаанд “New Image Cast” санал тоолох төхөөрөмжийг тус тус хэрэглэхийг зөвшөөрөхөөр тусгасан болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд олонх нь дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлтэй холбогдуулж

асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн байна. Үг хэлье. Нэг л гишүүн гарсан.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр Улсын Их Хурлын сонгууль болон орон нутгийн сонгуулийг ажлын өдөр буюу гурав дахь өдөр сүүлийн үед зохион байгуулж хийж байгаа.

Тэгээд энэ нь аль болох л бүх төлөөллүүдийг бүгдийг нь сонгуульд оролцуулах, сонгуулийн ирцийг нэмэгдүүлэх, иргэдийн сонгох эрхийг бүрэн эдлүүлэх ийм зорилготой.

Тэгэхээр сүүлийн үед Монгол Ардын намын нөхдүүд энэ сонгуулийг тав дахь өдөр хийдэг боллоо.

Энэ нь яаж байгаа юм бэ гэхээр сонгуульд аль болох тогтворгүй байр суурьтай, эрх чөлөөгөө бүрэн гүйцэд эдэлдэг тэр залуучуудыг сонгуульд оруулахгүй байх ийм зорилготой гэж үзэж байгаа.

Өөрөөр хэлбэл дөрөв дэх өдрийн орой, маргааш сонгуультай юм чинь дөрөв дэх өдрийн орой тэр хүмүүс, залуучууд яах вэ гэхээр дөрөв дэх, тав дахь, хагас сайнд нэг ойрхон газар яваад амарчихъя. Аль эсвэл энэ хугацаандаа амжуулаад ойрхон хөдөө байгаа аав, ээж, ах дүү нар дээрээ оччихъё гээд сонгуульд оролцохгүй байх ийм нөхцөл байдал бий болж байгаа.

Тэгээд үүний ард яаж байна гэхээр аль болох л өөрсдийгөө бат суурьтай дэмждэг тэр ахмадуудынхаа саналыг аваад л энэ сонгуульдаа ялалт байгуулах

ийм л зорилго агуулагдаж байгаа юм л даа.

Тэгээд эрх баригч нар юу гэж боддог вэ гэхдээр бид нарыг хэчнээн ядуу амьдруулж байсан ч, утаа тортогтой байлгаж байсан ч, авлига, хээл хахуулийг гааруулж байсан ч, энэ Монгол орныг эдийн засгаар доройтуулж байсан ч, хулгайн луйврыг нэмэгдүүлж байсан ч бид нарт санал өгдөг. Одоо дургүйцэж байсан ч гэсэн бид нарт санал өгдөг хэдэн намын үнэнч гишүүд маань байгаа. Тэд нар маань л санал өгөөд бид нар ялчихна гэдэг ийм л өчүүхэн бодлоор энэ өдрийг тавиад байгаа юм.

Ийм учраас сая хөдөөгүүр яваад уулзаж байхад тийм юм байхгүй байна лээ. Ялангуяа танай намын ахмадууд босож ирээд, тэр Түдэвтэй сумын н.Бадамдорж гэдэг ах Монгол Ардын намын бас нэг сургууль байсан. Дээр үеийн сургуульд сурсан. 40 жил удирдах ажил хийсэн н.Бадамдорж ах тэгж байна лээ шүү дээ.

Б.Пүрэвдорж оо, Монголын ард түмэн зуд болдгоороо болдог юм аа. Зудаас Монголын ард түмэн, малчин ард түмэн бол гардгаараа гардаг юм аа. Харин тэр дээр байгаа дарга зудаасаа салгаж өгөөрэй л гэж хэлж байна лээ шүү дээ.

Тэгэхээр танай намын үндсэн суурь хүмүүс чинь өнгөрсөн хугацаанд болсон эх захгүй хулгай зэлгийнээс болоод яг тийм баталгаатай санал өгөхгүй шүү.

Тийм учраас би нэг зүйлийг хэлэх гэж байгаа юм. Яг ингэж тав дахь өдөр болгодгоо боль оо.

Тэгээд санал нь байна шүү дээ, тийм ээ 11-ний өдөр орж ирсэн. Яг ингээд 11-ний өдөр орж байгаа. 11-ний өдөр нь болох дээр “модон хохимой өдөр”. Модон хохимой өдөр гээд тэр орон нутгийн сонгуулийг хийж, орон нутгийн өөрөө удирдах ёсыг тэгээд л нөгөө нэгжийн тухай хуулийг дагалдаж орж ирсэн Ашигт малтмалын тухай хуульд байдаг шигээ тэгээд л аль болох л иргэдийн эрхийг дордуулсан, тэр нутгийн өөрөө удирдах ёсыг л байхгүй болгох гэсэн ийм санаа агуулга дээр л бүх зүйл нь явж байгаа байхгүй юу даа.

Тийм учраас энэ нэг өчүүхэн зүйлээсээ болио. Тэр гурав дахь өдөр чинь их сайхан л өдөр байлаа шүү дээ. Тийм. 13-ны өдөр.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Байнгын саналаар “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёолол санал хураалт явуулья.

Ер нь тэгээд тэр “модон хохимой өдөр” гэдэг нь ч яаж байгаа юм гэдэг чинь бол тийм л өдөр юм байна. Санал хураалт. /алх цохив/

65.9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Одоо Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлийн хуралтай.

Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан орон нутагт томилолтоор ажиллах болсон тул Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хийх Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулдаг Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх олон улсын “**PISA-2022**” үнэлгээний Монгол Улсын үр дүнгийн талаар Ерөнхий сайдын мэдээллийн товыг хойшлуулж өгөхийг хүсье гэсэн Д.Амарбаясгалан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга гэсэн бичиг ирсэн байна.

Тийм учраас үдээс хойших хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг хойшлууллаа. /алх цохив/

Тийм. Даргын дэргэдэх зөвлөл 20 минут.

Баталсан тогтоолын эцсийн найруулгыг сонсьё.

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонсонд тооцлоо. /алх цохив/

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонсонд тооцлоо. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 26 минут үргэлжилж, 12 цаг 56 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**